



МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,
E-mail: comcor@iaac.mn, http://iaac.mn

2025. 03. 21 № 05/5492.
танай -ны № -т

Г ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ
ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН
ГАЗРЫН ДАРГА Д.ОЮУНБОЛД
ТАНАА

Г Хувийн ашиг сонирхлын урьдчилсан
мэдүүлгийг хянасан тухай

“Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ын Төлбөр авах үйл ажиллагааны хэлтсийн орлого төвлөрүүлэлт хариуцсан нягтлан бодогчийн албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн Ууганбаярын Сүнжидмаагийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хянахад ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Харин Төлбөр авах үйл ажиллагааны хэлтсийн тооцооны нягтлан бодогчийн албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн Баасанжавын Батсүх нь “Сономбюлдинг” ХХК-ийн, “Петровиллаже монголиа” ХХК-ийн мөн санхүүгийн тайлан бэлтгэн гаргах түүнтэй холбоотой зөвлөгөө өгөх чиглэлийн “Алтайбенчмарк” ХХК-ийн үүсгэн байгуулагч, хувь эзэмшигч, гүйцэтгэх захирлаар тус тус бүртгэлтэй байгаа нь нийтийн албан тушаалтан албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэх үед түүний хувийн ашиг сонирхол нийтийн ашиг сонирхолтой зөрчилдөх нөхцөл байдал бий болохоор байх тул Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн заасан хориглолт, хязгаарлалтыг хэрэгжүүлж ажиллах нь зүйтэй.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА,
ЭРХЭЛСЭН КОМИССАР

Т.ЭНХБОЛД



142503006589



10520300234